



I-VI/2021

Тархаасан: 2021 оны 7 дугаар сарын 17




Агаарын үнэмлэхүй их температур 2021 оны 6 дугаар сард Өмнөговь аймгийн Булган суманд +40.2⁰ С-д хүрсэн байна

Цаг агаар

Агаарын үнэмлэхүй их температур 2021 оны 6 дугаар сард Өмнөговь аймгийн Булган сумын нутгаар +40.2⁰, үнэмлэхүй бага температур Баянхонгор аймгийн Жаргалант суманд -6.7⁰С-д хүрлээ.

Зураг 1. Агаарын температур (°с), олон жилийн дундажтай¹ харьцуулснаар, станцын байршлаар, жил бүрийн 6 дугаар сарын байдлаар




¹ - 1981-2010 он

Цаг уур, орчны шинжилгээний газрын мэдээгээр 2021 оны 6 дугаар сард орсон хамгийн их хур тунадасны нийлбэр Сэлэнгэ аймгийн Ерөө сумын нутгаар 150.9 мм-т хүрсэн байна. Үнэмлэхүй их салхины хурд Булган аймгийн Гурванбулаг, Хэнтий аймгийн Галшар сумдад 29 м/с-д хүрсэн байна.

Агаарын чанар


Улаанбаатар хотын агаар дахь хүхэрлэг хийн сарын дундаж агууламж 2021 оны 6 дугаар сард агаарын чанарын стандарт хүлцэх агууламжаас давсан тохиолдол гараагүй байна.

Зураг 2. Улаанбаатар хотын агаар дахь хүхэрлэг хийн дундаж агууламж, жил бүрийн 6 дугаар сарын байдлаар, мг/м³



Улаанбаатар хотын PM 2.5 тоосонцрын агууламж 2021 оны 6 дугаар сард өмнөх оны мөн үеэс 0.009 мг/м³ (45.6%)-ээр, өмнөх сараас 0.003 мг/м³ (25.7%)-оор бага, PM 10 тоосонцрын агууламж өмнөх оны мөн үеэс 0.032 мг/м³ (41.6%)-аар, өмнөх сараас 0.012 мг/м³ (21.2%)-ээр тус тус бага байна. Харин хүхэрлэг хий өмнөх оны мөн үеэс 0.005 мг/м³ (82.5%)-аар их байсан бол, өмнөх сараас 0.008 мг/м³ (45.5%)-аар бага, азотын давхар исэл өмнөх оны мөн үеэс 0.005 мг/м³ (17.0%)-оор бага, өмнөх сарын түвшинд байна.

Зураг 3. Улаанбаатар хотын агаар дахь бохирдуулагч бодисуудын сарын дундаж агууламж, жил бүрийн 6 дугаар сарын байдлаар, мг/м³



Хүснэгт 1. Улаанбаатар хотын агаар дахь бохирдуулах бодисын агууламж агаарын чанарын стандарт хүлцэх агууламжаас давсан тохиолдлын тоо, станцаар, 2021 оны 6 дугаар сард

Станцын байршил	Азотын давхар исэл (NO ₂)	Тоосонцор (PM 10)
Мишээл экспо	-	1
Баруун 4 зам	5	1
13-р хороолол	-	1
32-ын тойрог	-	15
Хархорин	-	6
Ургах наран хороолол	-	2

Аюулт үзэгдэл, осол

Аюулт үзэгдэл, ослын тохиолдол 2021 оны эхний хагас жилд 2036 болж, өмнөх оны мөн үеэс 437 (17.7%)-гоор буурсан байна. Объектын түймэр 1382 удаа гарч, өмнөх оны мөн үеэс 550 (28.5%)-өөр буурсан байна.

Улсын хэмжээнд 2021 оны эхний хагас жилд мал, амьтны халдварт галзуу өвчний 14, шинэ төрлийн Корона вируст (Covid-19) халдварын 113670 тохиолдол тус тус бүртгэгдсэн байна.

Хүснэгт 2. Аюулт үзэгдэл, осол, жил бүрийн эхний хагас жилийн байдлаар

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2018 I-VI	2019 I-VI	2020 I-VI	2021 I-VI	$\frac{2021 \text{ I-VI}}{2020 \text{ I-VI}}$ %
Аюулт үзэгдэл, ослын тохиолдол	тоо	2 598	2 968	2 473	2 036	82.3
Амь насаа алдсан хүн	тоо	91	112	99	731	7.4 ¹
Түлэгдсэн, бэртсэн, өвчилсөн хүн	тоо	37	38	266	113 102	425.2 ¹
Шатсан гэр, орон сууц	тоо	913	1 001	926	425	45.9
Объектын түймэр	тоо	2 093	2 561	1 932	1 382	71.5
Учирсан хохирол	тэрбум төгрөг	15.3	6.4	105.3	10.8	10.3
Зарцуулсан зардал	сая төгрөг	9 954.0	1 045.8	173.5	1 809.8	10.4 ¹

¹ - Дахин их

Аюулт үзэгдэл, ослын улмаас 2021 оны эхний хагас жилд нийт 731 хүн амь насаа алдаж өмнөх сараас 361 (2.0 дахин)-аар, 113102 хүн түлэгдэж, бэртэж, өвчилж, хордсон хүний тоо өмнөх сараас 67819 (2.5 дахин)-аар нэмэгдсэн байна.

Бичил уурхай, нурангийн улмаас 5 хүн, усны ослоор 33 хүн, хүчтэй салхи, шуурганы улмаас 11 хүн, объектын түймрийн улмаас 36 хүн, шинэ төрлийн Корона вируст халдварын улмаас 616 хүн, бусад золгүй явдлын улмаас 30 хүн амь насаа алджээ.

Аюулт үзэгдэл, ослын улмаас 2021 оны эхний хагас жилд 425 гэр, байшин, орон сууц шатаж, өмнөх оны мөн үеэс 501 (54.1%)-аар буурсан байна. Харин 10.8 тэрбум төгрөгийн хохирол учирч, 1.8 тэрбум төгрөг зарцуулсан байна.

Аюулт үзэгдэл, ослоос 2021 оны эхний хагас жилд 1966 хүнийг аварч, 49.8 тэрбум төгрөгийн эд хөрөнгийг хамгаалсан байна.

Ойлголт, тодорхойлолт:

Агаарын бохирдол: Агаар мандалд нэг буюу хэд хэдэн химийн бодис дагнасан буюу хавсарсан байдлаар хүн, амьтан, ургамлын аймгийн амьдрал, ахуйн нөхцөл, үйл ажиллагаанд сөрөг нөлөөлөл үзүүлж, стандартаар тогтоосон хүлцэх хэм хэмжээнээс давсан агаар дахь бохирдуулах бодис тодорхой хугацаагаар байхыг ойлгоно.

Аюулт үзэгдэл: Хүчтэй цасан болон шороон шуурга, ган, зуд, үер, газар хөдлөлт, цөлжилт болох, гал түймэр, хүн, мал, амьтны болон ургамлын гоц халдварт өвчин гарах, хортон мэрэгчид тархах зэргийг ойлгоно.

Гамшиг: Аюулт үзэгдэл, техникийн холбогдолтой осол, алан хядах ажиллагаа, дэлбэрэлтийн улмаас олон хүний эрүүл мэнд, амь нас хохирох, мал, амьтан олноор хорогдох, эд хөрөнгө, хүрээлэн байгаа орчинд улс, орон нутгийн дотоод нөөц боломжоос давсан хохирол учрахыг ойлгоно.

Зөвшөөрөгдөх түвшин: Хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэхгүй байх агаар дахь физикийн бохирдуулагчийн зөвшөөрөгдөх түвшинг ойлгоно.

Хүлцэх агууламж: Хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэхгүй байх агаар дахь химийн бохирдуулагчийн зөвшөөрөгдөх хэмжээг ойлгоно.



Эх үүсвэр: Цаг уур, орчны шинжилгээний газар, Онцгой байдлын ерөнхий газар

Мэдээлэл авах линкүүд:

<http://www.nso.mn/>

<http://www.1212.mn/>

Дараагийн мэдээ тархах хуваарь: 2021 оны 8 дугаар сарын 17

Эдийн засгийн статистикийн
газрын дарга Э.Эрдэнэсан
Утас : (976-51)-266414

Эдийн засгийн статистикийн
газрын статистикч Г.Цэвэлмаа
Утас : (976-51)-261563

